



# БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

## *Булган аймгийн 2017 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан*



*Байгаль хамгаалах сангаас хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, арга хэмжээнүүдээс холбогдох хууль эрх зүйн акттай бүрэн нийцээгүй төсөл, хөтөлбөр, арга хэмжээг ИТХ-аар баталан хэрэгжүүлсэн, сангуудаас хийгдсэн ажлын хүрээнд бий болсон хөрөнгийг зохих байгуулагад хүлээлгэж өгөөгүй орлогод аваагүй байна.*

**АУДИТЫН ТАЙЛАНГ  
БЭЛТГЭСЭН:**

Булган аймаг дахь  
Төрийн аудитын газар

Дарга, тэргүүлэх  
аудитор  
Д.Анхбаяр

Аудитын менежер  
Ж.Энхцоодол

Ахлах аудитор  
П.Содном

Аудитор  
А.Сувдаа

2018 оны 04 дүгээр  
сар

Уг тайланг аймгийн  
Төрийн аудитын  
газраас авч үзнэ үү:

Аудитын тайлантай  
холбоотой асуудлаар  
нэмж тодруулах, асууж  
лавлах зүйл байвал  
70342495, 70342716  
утасаар  
факс:70342580  
дугаараар харилцана  
уу

ХАЯГ:

Булган сум 5-р баг  
Нутгийн удирдлагын  
ордон  
Өрөө № 403 тоот  
Bulgan@audit.gov.mn

Товчилсон үгийн тайлбар..... 3  
Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй, шалгуур  
үзүүлэлт.....4-5

**Бүлэг 1. Төсвийн төлөвлөлт .....5-10**

Орон нутгийн төсвийн орлого, зарлагыг төлөвлөхдөө  
боломжит орлого бүрдүүлэх нөөцийг бүрэн дайчлах,  
зарцуулалтыг холбогдох хууль, эрх зүйн акттай бүрэн нийцсэн  
төсөл хөтөлбөрийг төлөвлөн батлах шаардлагатай байна.

**Бүлэг 2 Төсвийн орлогын бүрдүүлэлт..... 11-14**

Тайлант онд 10 нэр төрлийн орлого 366.0 сая төгрөгөөр  
тасарч, 15 нэр төрлийн орлого нийт 2615.0 сая төгрөгөөр  
давж нийт орлого төлөвлөлтөөс 12.1 хувиар буюу 2249.0 сая  
төгрөгөөр давж биелэсэн байна. Биелэлтэнд ус, рашааны нөөц  
ашигласны татвар 2107.0 сая төгрөгөөр давж биелэсэн  
байдал ихээхэн нөлөөлжээ.

**Бүлэг 3 Төсвийн зарлагын гүйцэтгэл .....14-27**

Зардлыг зүйл анги бүрээр баталсан дүнтэй харьцуулахад  
зардлын ангилалаар 8 зүйл ангилалын зардал 336.9 сая  
төгрөгөөр хэтрүүлсэнч бусад бараа үйлчилгээний зардлаас  
гүйлгэн зарцуулжээ.

Дүгнэлт.....27-28

Зөвлөмж.....28-29

## ТОВЧИЛСОН ҮГСИЙН ЖАГСААЛТ

УИХ	Улсын Их Хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
БСШУС	Боловсрол, соёл, шинэжлэх ухаан, спортын
ЭМС	Эрүүл мэндийн сайд
ХНХС	Хөдөлмөр, нийгмийн хамгаалалын сайд
БХБС	Батлан хамгаалах
ОНТЕЗ	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч
БСУГ	Боловсрол, соёл урлагийн газар
ГХБХБГ	Газарын харилцаа, барилга хот байгуулалтын газар
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
ОУВС	Олон улсын валютын сан
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
БХС	Байгаль хамгаалах сан
СХС	Сум хөгжүүлэх сан
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
СТА	Санхүүгийн тайлангийн аудит
НББ	Нягтлан бодох бүртгэл
ЭМТ	Эрүүл мэндийн төв
ААН	Аж ахуйн нэгж
ХХК	Хязгаарлагдмал хувьцаат компани
ТЭЗҮ	Техник, эдийн засгийн үнэлгээ

## **Аудитын зорилт, хамарсан хүрээ, арга зүй**

### **Аудитын нэр:**

Булган аймгийн 2017 оны төсвийн гүйцэтгэл

### **Аудитын код:**

БУА-2018/01/СТА-ТЕЗ

### **Аудит хийх бүрэн эрх, үндэслэл:**

Аудитыг гүйцэтгэхдээ Монгол Улсын Ерөнхий аудиторт Үндэсний аудитын газраас 2018 онд нийлүүлэх бүтээгдэхүүн ажил, үйлчилгээний төлөвлөгөө, Булган аймаг дахь Төрийн аудитын газрын 2018 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэн Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд хийж гүйцэтгэв.

### **Аудитын зорилт:**

Булган аймгийн 2017 оны төсвийн орлого, зарлагыг үндэслэлтэй төлөвлөж, хэрэгжүүлсэн эсэх, гүйцэтгэлийг үнэн зөв илэрхийлсэн эсэхийг шалган, нэгдсэн төсвийн гүйцэтгэлд аудит хийж, дүгнэлт зөвлөмж боловсруулан дүнг холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдсэн.

Дээрх зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтын дагуу аудитыг хийж гүйцэтгэлээ.

- 1.Нэгдсэн төсвийн орлого, зарлагын төлөвлөлтийн үндэслэлтэй төлөвлөсөн үү?
- 2.Нэгдсэн төсвийн орлогын бүрэн төвлөрүүлсэн үү?
- 3.Нэгдсэн төсвийн зарлагын гүйцэтгэл бодитой байна уу?

### **Аудитын хамрах хүрээ:**

Аудитаар Орлогын шилжүүлэг, орон нутгийн төсвийн орлогын бүрдүүлэлт, төсвийн орлого, зарлагыг баталсан аймаг, сумдын ИТХ-ын тогтоол, 2017 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан тэнцэл, судалгаа, мэдээлэл болон бусад баримт материалд тулгуурлан аудит хийв.

### **Аудитын арга зүй:**

Аудитыг гүйцэтгэхэд Төрийн хяналт шалгалтын стандарт, гүйцэтгэлийн аудитын арга зүй болон санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагыг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга, лавлагаа авах, тайлан баримт материалд тулган баталгаажуулалт, дүн шинжилгээ хийж, судалгаа хийж, аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох зүйл цуглуулан дүгнэлт, зөвлөмж, боловсруулав.

### **Аудитад ашигласан шалгуур үзүүлэлтүүд:**

Аудитад дараахь хууль, тогтоомжийг шалгуур үзүүлэлт болгов.

- Төсвийн тогтвортой байдлын тухай хууль
- Төсвийн тухай хууль
- Монгол Улсын 2017 оны төсвийн тухай хууль, ,
- Төрийн аудитын тухай хууль,
- Татварын багц хуулиуд
- Холбогдох бусад хууль тогтоомж, эрхийн актууд,

### **Аудит хийх хугацаа, бүрэлдэхүүн:**

Аудитыг аймгийн Төрийн аудитын газрын дарга Д.Анхбаяр удирдаж, аудитын менежер Ж.Энхцоодол үе шатны болон чанарын хяналтыг хэрэгжүүлж, санхүүгийн аудитын багийн ахлах аудитор П.Содном, аудитор А.Сувдаа нар төлөвлөгөөний дагуу гүйцэтгэлээ.

### **Үндсэн мэдээлэл:**

Булган аймгийн 2017 оны төсвийн орлого нь татварын ба татварын бус орлого, орлогын шилжүүлэг, төсөвт байгууллагуудын өөрийн орлого, сумдаас төвлөрүүлэх орлогоос бүрдсэн бөгөөд уг эх үүсвэрээр Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 9 дэх заалтуудын дагуу 2017 онд жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлдээ аудит хийлгэх, аймгийн төсвийн төвлөрүүлэн захирагчийн жилийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд тайлангаа нэгтгүүлдэг Төрийн сан болон аймаг, сумын ИТХ, ЗДТГ, баг, Засаг даргын нөөц сан, орон нутгийн хөгжлийн сан, нийгмийн халамжийн сан, орон нутагт хэрэгжүүлж байгаа сум болон баг хөгжүүлэх сан, жижиг дунд үйлдвэрийг дэмжих сан, байгаль хамгаалах сан, Гамшигаас хамгаалах сан, аймгийн Байнгын онцгой комисс, Цэргийн штаб зэрэг орон нутгийн байгууллага, нэгж, Эмийн эргэлтийн сангийн аж ахуйн нэгж, орон нутгийн өмчит үйлдвэрийн газар болон ОНХС, СХС, төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой, төсвийн байгууллагууд, тусгай зориулалтын шилжүүлэгтэй ерөнхий боловсролын сургууль, хүүхдийн цэцэрлэг, Соёлын төв, Эрүүл мэндийн төв нийт аймгийн хэмжээгээр 203 байгууллагуудыг санхүүжүүлсэн байна.

УИХ-аас 2017 оны төсөвт хоёр удаа тодотгол хийсэнтэй холбоотойгоор аймгийн төсөвт 2 удаа тодотгол хийн аймгийн төсвийг 51986.8 сая төгрөгөөр төлөвлөн баталж Гүйцэтгэлээр орон нутгийн төсвийн нийт орлого 112.1 хувь, нийт зарлага 93.2 хувийн биелэлттэй тайлагнасан байна.

### Төрийн Аудитын газар

#### **Бүлэг 1**

*Орон нутгийн төсвийн орлого, зарлагыг төлөвлөхдөө боломжит орлого бүрдүүлэх нөөцийг бүрэн даачлаагүй, зарлагын хувьд холбогдох хууль, эрх зүйн акттай бүрэн нийцээгүй төсөл хөтөлбөрийг төлөвлөн баталсан байна.*

Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад төсвийн тогтвортой байдлыг хангасан байх, төсвийн иж бүрэн, үнэн зөв байдлыг хангасан байх, санхүү төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх, ил тод байдлыг хангасан байх,

хариуцлагатай байх зарчмуудыг баримтална. Төсвийг төлөвлөх, батлах, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага болох төсвийн захирагч нь төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Аймгийн СТСХ нь 2017 оны төсвийн төслийг Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлд заасан зарчим, УИХ-ын 2016 оны 47 дугаар тогтоол, аймгийн эдийн засаг, нийгмийн 2017 онд хөгжүүлэх зорилт зэргийг баримтлан боловсруулахдаа УИХ-аар бүх шатны ТЕЗ нарын төсвийн багцыг 1 хувиар, төрийн захиргааны албан хаагчдын тоог нэмэгдүүлээгүй, цалингийн зардлыг 11 хувиар тус тус бууруулсан ч орон тоонд өөрчлөлт оруулаагүй, мөрдөгдөж байгаа хуулиудад орсон өөрчлөлтүүдийг тусгаснаараа онцлог байна.

УИХ-аас баталж, сангийн яамнаас хуваарилан хянаснаар 2017 онд орон нутгийн орлогоор 17906.1 сая төгрөг оруулах төлөвлөгөө ирүүлснийг аймгийн ИТХ-ын 2017.12.04-ны өдрийн хуралдааны 06/01 тоот тогтоолоор аймагт төвлөрөх татварын орлогыг 17069.2 сая төгрөгөөр, сумдын ИТХ-ын хуралдааны тогтоолоор суманд төвлөрөх орлогыг 1689.4 сая төгрөгөөр буюу аймгийн дүнгээр нийт 18785.6 сая төгрөгийн орлого оруулахаар төлөвлөн батлахдаа цалин хөлс 96.0, үйл ажиллагааны орлого 24.7, шууд бус орлого 246.7, хог хаягдлын үйлчилгээний хураамж 49.9, Улсын тэмдэгийн хураамж 54.0, ан амьтны нөөц ашигласны төлбөр 32.6, түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 30.8 сая тус тус нэмэгдүүлэн баталсан бол ойн нөөц ашигласны төлбөр 36.3 сая төгрөгөөр бууруулан баталсан байна.

#### **Аймгийн төсөв:**

Төсвийн төсөлд аймгийн Төрийн аудитын газраас нэмэлтээр холбогдох тооцоолол, судалгааг хийн хөрөнгийн үр ашгийг дээшлүүлэх, орлого нэмэгдүүлэх саналыг хүргүүлсэн бөгөөд аймгийн ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 05-ны өдрийн “Аймгийн 2017 оны төсөв батлах тухай” 03 дугаар тогтоолоор аймгийн орон нутгийн төсвийн зарлагын нийт дүн, төсөв захирагчдын төсвийн жилд зарцуулах зардлын дүнг 49206.9 сая төгрөгөөр, түүнийг санхүүжүүлэх эх үүсвэрийг аймгийн орон нутгийн төсвийн орлогыг 18304.6 сая төгрөг, орон нутгийн хөгжлийн санд улсын төсвөөс авах орлогын шилжүүлгийг 1977.0 сая төгрөгөөр, тусгай зориулалтын шилжүүлгийн 28925.2 нийт дүнг 49206.9 сая төгрөгөөр баталсан байна.

Улсын төсвөөс дэмжлэг авдаггүй цөөхөн аймгуудын нэг нь манай аймаг бөгөөд 2017 онд улсын төсөвт төвлөрүүлэх хөрөнгийг 516.4 сая төгрөгөөр тусган баталсан байна.

Тайлант оны төсөвт аймгийн ИТХ-ын 05 дугаар сарын 12-ны өдрийн 04, 12 дугаар сарын 04-ний өдрийн 06 дугаар хуралдаанаар хоёр удаа тодотгол хийжээ. Эхний тодотголыг төсвийн жилийн дундуур буюу 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 04 дүгээр хуралдаанаар тодотгожээ.


УИХ-ын 29 дүгээр тогтоолоор 2017 оны төсвийг тодотгон баталж зардлыг хэмнэх, үр ашгийг дээшлүүлэхээр болсны дагуу төрийн албан хаагчдын цалин хөлсийг царцааж, зэрэг дэв ахиулахгүйгээс гадна зөвхөн эрүүл мэнд, боловсрол, цагдаа, онцгой байдлын салбараас 2 албан хаагч тэтгэвэрт гарах тохиолдолд 1

албан хаагчийг (2:1) нөхөн томилохыг 2017-2019 онд хийхээр чиглэл болгосонг үндэслэн дараах нөхцөл шалтгаанаар төсөвт тодотгол хийхээр болсон байна.

- УИХ-ын 2017 оны 04 дүгээр сарын 14-ний тогтоолоор улсын төсвийг тодотгон баталсан,
- Төсөвт байгууллагуудын 2016 онд үүссэн болон 2017 онд үүсэхээр тооцоологдсон урсгал зардлын өрийг барагдуулах,
- Төсөвт төвлөрүүлэх орлого нэмэгдэж, ОНХС-гийн эх үүсвэр өөрчлөгдсөн

Аймгийн төсөвт тодотгол хийхтэй холбогдуулан ИТХ-ын төлөөлөгч нарт СТСХ-ээс тодотголын танилцуулгыг цахимаар хүргүүлсэн бөгөөд хариу ирүүлсэн байдлыг хүснэгтээр харуулбал дараах байдалтай байна.

Утга	ИТХ-ын төлөөлөгчдийн тоо	Эзлэх хувь
Санал ирүүлсэн	12	36.4%
Нэмэлт саналгүй	17	51.5%
Хариу ирүүлээгүй	4	12.1%
<b>Нийт</b>	<b>33</b>	<b>100%</b>



ИТХ-ын 04 дүгээр хуралдаанаар 2017 оны төсөвт ХХОАТ-ын буцаалтыг 24.8, ОНХС-гийн шилжүүлгийг 232.1, тусгай зориулалтын шилжүүлгийг 19.4 сая төгрөгөөр тус тус бууруулж оны эхний үлдэгдлээс 1402.3 сая төгрөг нэмж орохоор тусган нийт орлогыг 1175.6 сая төгрөгөөр буюу батлагдсан төсвөөс 2.4 хувиар нэмэгдүүлж, сумдын ОНХС-д олгох санхүүгийн дэмжлэгийг 88.1 сая төгрөгөөр буюу 13.4 хувиар бууруулж төсөвт байгууллагуудын зардлыг 1087.6, улсын төсвийн төвлөрүүлэх шилжүүлгийг 176.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж нийт зардлыг баталсан төсвөөс 2.4 хувиар буюу 1175.5 сая төгрөгөөр нэмж баталсан байна. *Дэлгэрэнгүйг хүснэгт 1-ээс харах/*

Хоёр дахь тодотголыг аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн 06 дугаар хуралдаанаар тодотгон баталсан байна.

УИХ-ын 2017 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн тогтоолоор 2017 оны төсвийг ОУВС-тай хамтран хэрэгжүүлж буй “Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөр”-ийн хүрээтэй холбогдуулан төсөвт тодотгол хийсэн байна. Уг тодотголоор суурь зарлагыг 1000.0 сая төгрөгөөр нэмж, аймгийн төсвөөс улсын төсөвт төвлөрүүлэх орлогыг 290.4 сая төгрөг болгон баталсны дагуу аймгийн төсөвт дараах өөрчлөлтийг оруулсан байна.

Тодотголоор төсөвт байгууллагын өөрийн орлогыг 61.3, тусгай зориулалтын шилжүүлгийг 630.0, оны эхний үлдэгдлийг 873.2 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлсэн нь өмнөх тодотголын дүнгээс 3.1 хувиар буюу 1564.4 сая төгрөгөөр орлогыг, төсөвт

байгууллагуудын урсгал зардлыг 1966.6 сая төгрөгөөр нэмэгдүүлж улсын төсвийн төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээг 402.0 сая төгрөгөөр бууруулж баталсан байна.

**Аймгийн 2017 оны төсөвт орсон өөрчлөлт**

Хүснэгт 1 /сая.төг/

Үзүүлэлт		СТСХ-ээс өргөн барьсан төсвийн төсөл	ИТХ-ын 2016.12.05-ны 03/03 тогтоол	ИТХ-ын 2017.05.12-ны 04/04 тогтоол	ИТХ-ын 2017.12.04-ны 06/01 тогтоол
			Батлагдсан төсөв	Тодотгол I	Тодотгол II
<b>№</b>	<b>Аймгийн төсвийн орлого бүгд</b>	<b>48922.6</b>	<b>49246.7</b>	<b>50422.3</b>	<b>51986.8</b>
1	Оны эхний үлдэгдлээс	1177.3	1301.6	2703.9	3577.1
2	Урсгал орлого	16835.1	17022.9	17047.7	17109
2.1	<b>Татварын орлого</b>	<b>16361.5</b>	<b>16432.2</b>	<b>16457</b>	<b>16457</b>
2.1.1	Цалин хөлс түүнтэй адилтгах орлогын албан татвар	4138	4188	4188	4188
2.1.2	Хувь хүний орлогын албан татварын буцаалт	-520	-520	-495.2	-495.2
2.1.3	Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	380	380	380	380
2.1.4	Авто тээвэр болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	254.6	254.6	254.6	254.6
2.1.5	Газрын төлбөр	<b>321</b>	<b>321</b>	<b>321</b>	<b>321</b>
2.1.5.1	Үүнээс: газрын төлбөр	221	221	221	221
2.1.5.2	Газрын дуудлага худалдаа	100	100	100	100
2.1.6	Үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр	11787.9	11808.6	11808.6	11808.6
2.2	<b>Татварын бус орлого</b>	<b>473.6</b>	<b>590.7</b>	<b>590.7</b>	<b>652</b>
2.2.1	ОНӨ болон ОНӨ-ийн оролцоотой хуулийн этгээдийн ОНӨ-д ногдох хувьцааны ногдол ашиг	13.2	13.2	13.2	13.2
2.2.2	ОНӨ-ийн эд хөрөнгийг ашигласны төлбөр	12.9	12.9	12.9	12.9
2.2.3	Хүү торгуулийн орлого	250	250	250	250
2.2.4	Төсөвт байгууллагын өөрийн орлого	139.5	194.7	194.7	256
2.2.5	Нэр заагдаагүй бусад орлого	42	79.9	79.9	79.9
3	<b>Хөрөнгийн орлого</b>	<b>8</b>	<b>20</b>	<b>20</b>	<b>20</b>
3.1	Хөрөнгө борлуулсны орлого	8	20	20	20
4	<b>Тусламжийн орлого</b>	<b>30902.2</b>	<b>30902.2</b>	<b>30650.7</b>	<b>31280.7</b>
4.1	Санхүүгийн дэмжлэг				
4.2	Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	1977	1977	1744.9	1744.9
4.3	Тусгай зориулалтын шилжүүлэг	28925.2	28925.2	28905.8	29535.8
	<b>ТЕЗ, түүний харьяа байгууллага</b>	<b>16827.3</b>	<b>17003</b>	<b>17027.8</b>	<b>17089.2</b>
2.1.1	Аймгийн ЗДТГ-ын өөрийн орлого	19	19	19	19
2.1.2	Орон нутгийн Өмчийн газар	76.2	108.2	108.2	88.2
2.1.3	Гамшгаас хамгаалах сангийн орлого	50	50	50	50
2.1.4	Цэргийн дүйцүүлэх албаны төлбөрийн орлого	6.5	6.5	6.5	67.9
2.1.5	Усан бассейн сургалтын төвийн өөрийн орлого	19.2	19.2	19.2	19.2
	Малын эрсдэлээс хамгаалах сангийн зээлийн эргэн төлөлтийн орлого				20
2.1.6	Авто зам ашигласны төлбөрийн орлого	44.8	80	80	80
2.1.7	<b>Аймгийн татварын хэлтэс</b>	<b>16361.6</b>	<b>16432.2</b>	<b>16457</b>	<b>16457</b>



2.1.8	Санхүү төрийн сангийн хэлтэс		37.9	37.9	37.9
2.1.9	Торгууль, төлбөрийн акт бичдэг эрх бүхий байгууллагууд	250	250	250	250
3	Төсвийн захирагч	48907	49207	50382.5	51947.1
3.1	Төсвийн нийт зардал: үүнээс	317.3	337.3	372.2	374.9
	Урсгал зардал	317.3	337.3	372.2	374.9
	Хөрөнгийн зардал		0		
	<b>ИТХ-ын нарийн бичгийн дарга. Үүнээс:</b>	<b>317.3</b>	<b>337.3</b>	<b>372.2</b>	<b>374.9</b>
	Үндсэн үйл ажиллагаа	179	199	221.9	221.9
	Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	80	80	92	94.7
	ИТХ-д суудалтай намуудад олгох дэмжлэг	8.3	8.3	8.3	8.3
	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зохицуулах зөвлөлийн зардал	50	50	50	50
3.2	<b>Засаг дарга</b>	<b>48589.7</b>	<b>48869.7</b>	<b>50010.3</b>	<b>51572.2</b>
	Урсгал зардал	47186.3	46361.2	46436.1	47970.2
	Хөрөнгийн зардал	1403.4	2508.5	3574.2	3602
3.2.1	<b>Аймгийн Засаг даргын тамгын газар</b>	<b>1640.5</b>	<b>1653.2</b>	<b>1897.1</b>	<b>2303.7</b>
	Үндсэн үйл ажиллагаа	1061.4	1061.4	1160.3	1160.3
	Мэдээлэл сурталчилгааны зардал	6	18.7	18.7	18.7
	Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	82.2	82.2	82.2	101.7
	Орон нутгийн нөөц хөрөнгө	390.9	390.9	490.9	818
	Хөрөнгийн зардал	100	100	145	205
3.2.2	<b>Санхүүгийн хяналт, аудитын алба</b>	<b>75.3</b>	<b>75.3</b>	<b>87.5</b>	<b>89</b>
	Үндсэн үйл ажиллагаа	74.7	74.7	86.9	86.9
	Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	0.6	0.6	0.6	2.1
3.2.3	<b>Орон нутгийн Өмчийн газар</b>	<b>85.9</b>	<b>85.9</b>	<b>85.9</b>	<b>88</b>
	Үндсэн үйл ажиллагаа	85.7	85.7	85.7	85.7
	Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	0.2	0.2	0.2	2.3
3.2.4	<b>Байгаль орчин, аялал жуулчлалын газар</b>	<b>355</b>	<b>355</b>	<b>388.7</b>	<b>409.7</b>
	Үндсэн үйл ажиллагаа	351.6	351.6	385.3	393.1
	Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	3.4	3.4	3.4	16.6
3.2.5	<b>Хүүхдийн сувилалын ясли</b>	<b>114</b>	<b>114</b>	<b>114</b>	<b>116.4</b>
	Үндсэн үйл ажиллагаа	110.8	110.8	110.8	110.8
	Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал	3.2	3.2	3.2	5.6
3.2.6	<b>Усан бассейний сургалтын төв</b>	<b>144.8</b>	<b>144.8</b>	<b>144.8</b>	<b>146.3</b>
	Үндсэн үйл ажиллагаа	144.8	144.8	144.8	144.8
	Ажил олгогчоос олгох тэтгэмж урамшуулал				1.5
3.3	Сумдад олгох санхүүгийн дэмжлэг	3572.2	3660.1	3916.2	4570.3
3.4	Сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлэг	655.6	655.6	567.5	567.5
3.5	Сумдад олгох тусгай зориулалтын шилжүүлгийн хэмжээ	26758.3	26758.3	26758.3	27735.2
3.6	Улсын төсвийн төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ	516.4	516.4	692.4	290.4

Нийт орлого 2249.0 сая төгрөгөөр буюу 12.1 хувиар давж биелсэн нь өмнөх оноос 949.4 сая төгрөгөөр өссөн байна. Орлогыг нэр төрлөөр үзвэл жигд ханган биелүүлээгүй буюу 15 нэр төрлийн 2615.3 сая төгрөгөөр давж биелсэн бол 10 нэр төрлийн орлого 366.1 сая төгрөгөөр тасарсан байна. /Хүснэгт 2-оос харах/

Татварын орлогоор 2017 онд аймгийн төсөвт 18237.1 сая төгрөг төвлөрүүлэхээс 20509.7 сая төгрөг төвлөрч, төлөвлөгөөг 2272.6 сая төгрөгөөр давуулан биелүүлжээ. Ус рашааны нөөц ашигласны төлбөр 2106.9, газрын төлбөр 84.1, шууд бус орлого 180.5 сая төгрөгөөр харьцангуй их хэмжээгээр давж биелсэн нь орлогыг бодиттой төлөвлөөгүй нь илэрхийлж байна.

Усны төлбөр нийт дүнгээр биелж байгаа ч уул уурхайгаас орох усны төлбөрийг дутуу төлөвлөсөн байна. Тухайлбал: “Цагаан уулын магнит” ХХК 30.9, “Эко алтан заамар” ХХК 30.3, Ориент майнинг инвестмент 7.2 сая төгрөг зэрэг төсөвт төлөвлөөгүй 86.6 сая төгрөгийн орлого оржээ.

Төсвийн тухай хуулийн 6.3.4, НББ-ийн тухай хуулийн 18.1, 18.2 болон Сангийн сайдын 2017 оны 216 дугаар журмыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй зарим төсөвт байгууллагаас дурьдвал Орхон сумын суурь боловсролын сургууль байгууллагын дотоод журмын 9.2.17-д заасны дагуу дотуур байранд оршин суугч сарын 50.0 мянган төгрөгийн түрээс төлөхөөр заасны дагуу тайлант онд түүрээсийн 2.3 мянган төгрөг бэлнээр орсон боловч нэмэлт санхүүжилтийн дансаар дамжуулаагүй, санхүүгийн тайланд тусгаагүй, эрх бүхий албан тушаалтны шийдвэргүй зарцуулснаас үзэхэд орлого бүрдүүлэх нөөц боломжийг бүрэн дайчилж төсвийг төлөвлөөгүй байна.

Аймгийн төсвийн нийт зарлага 2017 оны жилийн эцсийн байдлаар 57908.9 сая төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 53941.9 сая төгрөгийн буюу 93.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

Батлагдсан төлөвлөгөөг аймгийн Засаг дарга 3825.9 сая төгрөгөөр, БСШУСайдын төсвийн шууд захирагч 306.5 сая төгрөгөөр, Эрүүл мэндийн төсвийн шууд захирагч 15.2 сая төгрөгөөр тус тус бодит бус хэмнэлт үүссэн байна.

Орон нутгийн төсвийн зарлагыг төлөвлөхдөө үндэслэл муутай төлөвлөсөн байна. Тухайлбал:

- *Засгийн газрын 2010 оны 271 дүгээр тушаалаар “Үндэсний их баяр наадмын арга хэмжээнд зориулан төсвөөс гаргах санхүүжилтийн жишиг дээд хэмжээг аймагт 10.0 (арван) сая төгрөг, суманд 5.0 (таван) сая төгрөг байхаар тус тус тогтоож, бөх, уяач, харваачдад төсвөөс олгох бай, шагналын жишиг хэмжээг хавсралт ёсоор шинэчлэн баталсугай” гэж заасныг зөрчин баяр наадмын зардлыг 40.0 сая төгрөгөөр хэтрүүлэн аймгийн ОНХС-гаас 50.0 сая төгрөгийг зарцуулах,*
- *Төсвийн тухай хуулийн 29.4-д “Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана” гэж заасныг зөрчин зураг, төсөв, эдийн засгийн тооцоолол, хэрэгжүүлэх ажлын төлөвлөлт, хөтөлбөргүйгээр нийт 6 төсөл арга хэмжээнд 1638.8, Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлангах журам”-ыг тус тус зөрчин БХС-гаас 5 төсөл, хөтөлбөр, арга хэмжээнд 61.5 сая төгрөгийг зарцуулах,*
- *Төсвийн тухай хуулийн 42.7-д “Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгаагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно” гэсэн заалтыг зөрчин хэзээ, хэрхэн, юунд зарцуулах нь тодорхойгүй шаардлагатай үед зарцуулах зардалд 78.2 сая төгрөгийг БХС-гаас зарцуулахаар тус тус төлөвлөн баталсан байна.*

Төрийн Аудитын газар

**Бүлэг 2** *Уул уурхайгаас ус ашигласны төлбөрийн орлого болон торгуулийн орлогыг бүрэн төвлөрүүлэх нөөц боломжийг бүрэн даачилж ажиллаагүй байна.*

УИХ-аас баталж, сангийн яамнаас хуваарилан хянаснаар 2017 онд орон нутгийн орлогоор 17906.1 сая төгрөг оруулах төлөвлөгөө ирүүлснийг аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 04-ний өдрийн хуралдааны 06/01 тоот тогтоолоор аймагт төвлөрөх татварын орлогыг 17069.2, сумдын ИТХ-ын хуралдааны тогтоолоор суманд төвлөрөх орлогыг 1689.4 аймгийн дүнгээр нийт 18785.6 сая төгрөгийн орлого оруулахаар төлөвлөн батлахдаа цалин хөлс 96.0, үйл ажиллагааны орлого 24.7, шууд бус орлого 246.7, хог хаягдлын үйлчилгээний хураамж 49.9, улсын тэмдэгийн хураамж 54.0, ан амьтны нөөц ашигласны төлбөр 32.6, түгээмэл тархацтай ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр 30.8 сая тус тус нэмэгдүүлэн баталсан бол ойн нөөц ашигласны төлбөр 36.3 сая төгрөгөөр бууруулан баталсан байна.

2017 оны нийт орлого 2249.0 сая төгрөгөөр буюу 112.1 хувиар давж биелэсэн нь төсвийн орлого өмнөх оноос 949.4 сая төгрөгөөр өссөн сайн талтай байна.

**Орон нутгийн төсвийн орлогын төлөвлөгөөний биелэлт**

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь	/ сая.төг/ Гүйцэтгэлээрх нийт дүнд эзлэх хувийн жин
<b>НИЙТ ОРЛОГО</b>	18785.7	21034.7	2249.0	112	100%
<b>Татварын орлого</b>	<b>18237.1</b>	<b>20509.7</b>	2272.6	112.5	97.5%
<b>Татварын бус орлого</b>	<b>528.6</b>	<b>476.2</b>	-52.4	90.1	2.3%
<b>Хөрөнгийн орлого</b>	20.0	48.8	28.8	243.9	0.2%

Орон нутгийн орлогын 97.5 хувиар буюу 20509.7 сая төгрөг татварын орлогоос, 2.3 хувиар буюу 476.2 сая төгрөг татварын бус орлогоос, 0.2 хувиар буюу 48.8 сая төгрөг хөрөнгийн орлогоос тус тус бүрджээ.

Орон нутгийн төсвийн орлогын тайлангаас үзэхэд батлагдсан орлогын төлөвлөгөө нийт дүнгээрээ 2249.0 сая төгрөгөөр давж биелэгдсэн ч орлогын нэр төрлөөр үзвэл жигд ханган биелүүлээгүй байна. Тайлант онд 15 нэр төрлийн орлого 2615.3 сая төгрөгөөр давж биелсэн бол 10 нэр төрлийн орлого 366.1 сая төгрөгөөр тасарсан байна. Орлогын төлөвлөгөөнөөс давсан болон тасарсан орлогуудыг нэр төрлөөр авч үзвэл дараах байдалтай байна.

**Давсан орлого:**

/сая.төг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ОРЛОГО	13554.7	16170.1	2615.3	119.3

Хөрөнгийн орлого	9.1	104.5	95.4	1145.9
Шууд бус орлого	546.7	727.1	180.4	133.0
Үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар	380.0	385.2	5.2	101.4
Автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	254.6	272.5	17.9	107.0
Түгээмэл тархацтай ашигт малтмал ашигласны төлбөр	65.9	74.2	8.3	112.7
Ашигт малтмалаас бусад байгалийн нөөц ашигласны зөвшөөрөл олгох	130.0	136.6	6.6	105.1
Газрын төлбөр	221.0	305.1	84.1	138.1
Ан амьтны нөөц ашигласны төлбөр	26.2	51.4	25.2	196.0
Ус, рашааны нөөц ашигласны төлбөр	11859.3	13966.2	2107.0	117.8
Байгалийн ургамал ашигласны төлбөр	1.2	2.1	0.9	173.7
Хувьцааны ногдол ашиг	13.2	38.4	25.2	290.4
Бусад орлого	7.5	16.7	9.2	222.3
Түрээсийн орлого	20.0	24.6	4.6	123.0
Хүүгийн орлого	0.0	16.6	16.6	#DIV/0!
Төрийн болон орон нутгийн өмчид бүртгэлтэй хөрөнгө борлуулсны орлого	20.0	48.8	28.8	243.9

Нийт татварын орлогыг төлөвлөгөөнөөс 2272.6 сая төгрөгөөр давуулан биелүүлэхдээ ус рашааны нөөц ашигласны төлбөр 2106.9, газрын төлбөр 84.1, шууд бус орлого 180.5 сая төгрөгөөр буюу харьцангуй их хэмжээгээр давж биелсэн нь орлогыг бодиттой төлөвлөөгүйг илэрхийлж байна.

Аж ахуйн нэгжийн ус ашигласны татварын орлогыг төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая.төг/

Д/д	ААН-ийн нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Гүйцэтгэлийн хувь
1	Өгөөж баян хангай	31.6	24.7	-6.9	78.2%
2	Хүслэмж	4.7		-4.7	0.0%
3	ГБНБ	73.6	54	-19.6	73.4%
4	Мондолимет	450	107.3	-342.7	23.8%
5	Хосхас	36.9	33.4	-3.5	90.5%
7	Хамтын эх булаг	18.1	5.7	-12.4	31.5%
8	Шарнарст	8		-8	-100.0%
9	Эрдэнэт үйлдвэр	11100	13550	2450	<b>122.1%</b>
10	ЭДЦС	70	80.8	10.8	<b>115.4%</b>
11	Заамар гоалд		2.8	2.8	-100.0%
12	Ориент майнинг инвэстмент		7.2	7.2	-100.0%

13	Баянгол эко заамар		7	7	-100.0%
14	Эко алтан заамар		30.3	30.3	-100.0%
15	Төсөлч		8	8	-100.0%
16	Цагаан уулын магнит		30.9	30.9	-100.0%
17	Тэргүүн майнинг		0.4	0.4	-100.0%
<b>Нийт</b>		<b>11792.9</b>	<b>13942.5</b>	<b>2149.6</b>	<b>118.2%</b>

Тайлант онд усны төлбөр нийт дүнгээр биелж байгаа ч уул уурхайгаас орох усны төлбөрийг дутуу төлөвлөжээ. Тухайлбал: “Цагаан уулын магнит” ХХК 30.9, “Эко алтан заамар” ХХК 30.3, Ориент майнинг инвэстмент 7.2 сая төгрөг зэрэг төсөвт төлөвлөөгүй 86.6 сая төгрөгийн орлого орсон бол Эрдэнэт үйлдвэр 2450.0 сая төгрөгийг төлөвлөснөөс илүү оруулсан бол Бүрэгхангай сумын “Монполимет” ХХК 342.7, “ГБНБ” ХХК 19.6, “Хамтын эх булаг” ХХК 12.4 сая төгрөгийг төлөвлөснөөс дутуу оруулсан байна.

#### Тасарсан орлого:

Хүснэгт 2  
/сая.төг/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
<b>НИЙТ ОРЛОГО</b>	5626.1	5260.1	-366.0	93.5
Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрх	4188.0	4138.3	-49.7	98.8
Үйл ажиллагааны орлого	214.0	128.5	-85.5	60.0
Бууны албан татвар	65.9	60.4	-5.5	91.7
Улсын тэмдэгтийн хураамж	189.0	151.7	-37.3	80.3
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	145.1	89.8	-55.3	61.9
Бусад татвар	2.0	0.0	-2.0	0.0
Ойн нөөц ашигласны төлбөр	331.7	310.7	-21.0	93.7
Нохойн татвар	2.5	0.7	-1.8	27.1
Торгуулийн орлого	402.5	355.6	-46.9	88.4
Бусад орлого	85.4	24.3	-61.1	28.5

Цалин, хөдөлмөрийн хөлс тэдгээртэй адилтгах орлого 49.7, үйл ажиллагааны орлого 85.5, улсын тэмдэгтийн хураамж 37.2, хог хаягдлын үйлчилгээний хураамж 55.4, торгуулийн орлого 46.8 сая төгрөгөөр тус тус тасарсан байна.

Тасарсан орлого болох торгуулийн орлого 402.5 сая төгрөгөөр төлөвлөн гүйцэтгэлээр 355.6 сая төгрөгийн орлого төвлөрүүлж 46.8 сая төгрөгөөр тасарсан байна. Аймгийн Цагдаагийн газрын бэлэн бус торгуулийн машинаар 2017 онд 543.6 сая төгрөгийн торгууль бүртгэгсэн, торгуулийн орлогыг оруулах талаар тодорхой

хариуцсан газар байхгүйгээс орлого тасарч, тооцоогоор торгууль бичигдсэн 200.0 сая төгрөг төсөвт төвлөрөөгүй байна. Тухайлбал: Баяннуур сумын хүү торгуулийн орлогыг оны эхэнд 30.1 сая төгрөгөөр баталж тодотголоор 10.0 сая төгрөг болгон бууруулан баталжээ. Орлогыг анх төлөвлөхдөө 2016 онд 15.0 сая төгрөг бэлэн бус торгуулийн машинаар бичигдсэн торгуулийг орохоор тооцон төлөвлөсөн, 2017 онд 23.4 сая төгрөгийн торгууль бичигдсэн ч 9.1 сая төгрөгийн гүйцэтгэлтэй нийт 29.3 сая зөвхөн нэг сумын торгуулийн орлого орох боломж байна.

Төрийн Аудитын газар

**Бүлэг 3**

*Зардлыг зүйл анги бүрээр баталсан дүнтэй харьцуулахад зардлын ангилалаар 8 зүйл ангилалын зардал 336.9 сая төгрөгөөр хэтрүүлсэнч бусад бараа үйлчилгээний зардлаас гүйлгэн зарцуулжээ.*

Аймгийн төсвийн нийт зарлага 2017 оны жилийн эцсийн байдлаар 57908.9 сая төгрөгөөр төлөвлөгдсөнөөс 53941.9 сая төгрөгийн буюу 93.2 хувийн гүйцэтгэлтэй байна.

**2017 ОНЫ ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ЗАРЛАГЫН ГҮЙЦЭТГЭЛ**

Д/д	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Эзлэх хувь
1	Аймгийн Засаг дарга	28125.4	24299.5	45.2
2	БСШУсайдын	25151.3	24844.8	46.3
3	БХБсайдын	241.6	241.1	0.4
4	НХХсайдын	162.4	162.4	0.3
5	Эрүүл мэндийн сайдын	4228.4	4213.2	7.8
	<b>ДҮН</b>	<b>57909.1</b>	<b>53941.9</b>	<b>100.0</b>

Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн зарлагын гүйцэтгэлийг зориулалтаар авч үзвэл нийт зарлагын 45.2 хувь аймгийн Засаг дарга, 46.3 хувийг БСШУСайдын төсвийн шууд захирагчийн, 7.8 хувийг Эрүүл мэндийн сайдын төсвийн шууд захирагч зарцуулсан байгаа нь нийт зарлагын 99.3 хувийг эзэлж байна.

Төсвийн гүйцэтгэлийн хэтрэлт, хэмнэлтийг сайдын төсвийн шууд захирагчаар авч үзвэл:

Батлагдсан төлөвлөгөөг аймгийн Засаг даргын 3825.9 сая төгрөгөөр, БСШУСайдын төсвийн шууд захирагчаар 306.5 сая төгрөгөөр, Эрүүл мэндийн төсвийн шууд захирагчаар 15.2 сая төгрөгөөр тус тус хэмнэсэн байна.

**Орон нутгийн төсвийн нийт зардлыг бүтцээр нь харуулбал:**

Үзүүлэлт	Тайлант оны		хэтрэлт хэмнэлт
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл			
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	57,764.59	53,944.88	3,819.71
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	49,613.03	48,715.12	897.91
<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	40,659.82	39,628.17	1,031.65
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	22,137.07	22,002.39	134.68
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	2,451.55	2,437.70	13.85
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,188.82	5,094.02	94.80
Хангамж, бараа материалын зардал	1169.79	1160.58	9.21
Нормативт зардал	2,112.79	2,101.19	11.60
Эд хогшил, урсгал засварын зардал	592.20	589.07	3.13
Томилолт, зочны зардал	185.12	178.72	6.40
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	360.25	355.39	4.86
Бараа үйлчилгээний бусад зардал	6462.23	5709.11	753.12
Бусад урсгал шилжүүлэг	8615.99	8582.15	33.84
<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	5,545.61	4,299.94	1,245.66
<b>ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ</b>	2605.95	929.81	1,676.14
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	57764.59	53897.98	3,866.61
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	29,535.79	29,364.14	171.65
Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	29535.79	29364.14	171.65
<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>			(1,486.00)
Орон нутгийн төсвөөс	20,850.13	22,336.13	(1,486.00)
Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	1,744.95	1,744.95	0.00
<b>ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС</b>	7,378.66	2,197.71	5,180.95
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	2,656.81	1,999.59	657.22
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	159.85	198.12	(38.27)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	1,819.48	
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	1,944.25	

Дээрх хүснэгтээс харахад нийт зардалд бараа үйлчилгээний зардал 39626.6 сая төгрөг буюу 73.5 хувь, хөрөнгийн зардал 4299.9 сая буюу 7.9 хувь, татаасын зардал 34.5 сая төгрөг буюу 0.06 хувь, урсгал шилжүүлэг 9052.5 сая төгрөг буюу 16.8 хувийг тус тус эзэлж байна. 2017 оны төсвийн хэтрэлт хэмнэлтийг зардлын зүйл ангиар авч үзвэл:

- Цалин, шимтгэл, тогтмол зардал, хоол зэрэг нормативт зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал, хангамж, бараа материалын


зардал зэрэг урсгал зардлуудыг батлагдсан төлөвлөгөөнөөс 1033.0 сая төгрөгөөр, нийгэм халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн зардал нь 33.8 сая төгрөгөөр, хөрөнгийн зардал 1245.6 сая төгрөгөөр дутуу зарцуулагдсан байна.

Төсвийн зардлын гүйцэтгэлийг өмнөх таван онтой харьцуулан авч үзвэл дараах байдалтай байна.

/сая.төг/

Зардлын зүйл	2012	2013	2014	2015	2016	2017
<b>Урсгал зардал</b>	7791.1	40980.1	42579.3	38898.3	41099.5	48715.1
<b>Бараа үйлчилгээний зардал</b>	6850.3	35846.5	36359.8	33019.5	34720	39628.2
<b>Татаас ба урсгал шилжүүлэг</b>	940.8	5133.6	6219.5	5878.8	6379.5	9086.9
<b>Хөрөнгийн зардал</b>	881.4	3295.3	5929.6	12004.3	9176.5	5229.8
<b>Нийт зардал</b>	<b>8672.5</b>	<b>44275.4</b>	<b>48508.9</b>	<b>50902.6</b>	<b>50276</b>	<b>53944.9</b>

Гүйцэтгэлээр нийт зарцуулалт жил ирэх тусам тодорхой хэмжээгээр нэмэгдсэн ч урсгал болон хөрөнгийн зардлын зарцуулалт харилцан адилгүй байна. Нийт дүнд эзлэх үнийн дүнгээр графиклан үзвэл дараах байдалтай байна.



Графикаас харахад нийт зарцуулалтын урсгал зардал 40-50, бараа үйлчилгээнд 30-40, татаас урсгал шилжүүлэг 10, хөрөнгөнд 10-20 орчим хувийн зарцуулалтын гүйцэтгэлтэй байна. Хөрөнгийн зардал 2015 онд хамгийн өндөр байсан бол 2017 он хүртэл хөрөнгийн зарцуулалт буурч бусад зардал тодорхой хэмжээгээр өссөн байна.



**Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2017 оны  
нийт гүйцэтгэлийг сумдаар харуулбал:**

/сая.төг/

Сумын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Өөрчлөлт	Гүйцэтгэлийн хувь
Булган аймаг	18727.5	17305.2	-1422.3	92.4%
Баян-Агт	1870.4	1790.7	-79.7	95.7%
Баяннуур	1491.3	1363.4	-127.9	91.4%
Бугат	1344.6	1272.5	-72.1	94.6%
Булган	7877.9	7604.2	-273.7	96.5%
Бүрэгхангай	1851.2	1618.6	-232.6	87.4%
Гурванбулаг	2128.4	1911.4	-217	89.8%
Дашинчилэн	2048.6	1837.9	-210.7	89.7%
Могод	1720.5	1635.1	-85.4	95.0%
Орхон	1435.3	1340.3	-95	93.4%
Рашаант	2242.1	2141.9	-100.2	95.5%
Сайхан	2034	1848.8	-185.2	90.9%
Сэлэнгэ	2730.9	2476.2	-254.7	90.7%
Тэшиг	2262.7	2141.8	-120.9	94.7%
Хангал	1270.5	1180.6	-89.9	92.9%
Хишиг-Өндөр	1923.5	1797.0	-126.5	93.4%
Хялганат	2019.2	2004.7	-14.5	99.3%
Хутаг-Өндөр	2785.8	2671.6	-114.2	95.9%
<b>Нийт</b>	<b>57764.4</b>	<b>53944.9</b>	<b>-3819.5</b>	<b>93.4%</b>

Аймаг сумдыг гүйцэтгэлээрх дүнгээр авч үзвэл 3 сум 87.4-89.7, аймаг 8 сум 90.7-94.7, 5 сум 1 тосгон 95.0-99.3 хувийн гүйцэтгэлтэй байгаагаас хамгийн бага гүйцэтгэлтэй сум нь Бүрэгхангай бол нь Хялганат тосгон хамгийн өндөр гүйцэтгэлтэй байна.

Тайлант онд гүйцэтгэлээр 8 зүйл ангийн зардал хэтэрсэнг бүлэг доторх хэмнэлтээс шилжүүлэн зарцуулсан байна. Хүснэлтээр харуулбал:

/сая.төг/

Д/д	Зардлын зүйл ангилал	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Гүйцэтгэлээрх хувь
1	Цалин хөлс нэмэгдэл	2771.1	2773.3	2.2	100.1%
2	Тэтгэврийн даатгал	1561.7	1696.2	134.5	108.6%
3	Ажилгүйдлийн даатгал	44.3	49.9	5.6	112.6%
4	Тээвэр шатахуун	515.3	519.9	4.6	100.9%
5	Нормын хувцас, зөөлөн эдлэл	218	226.6	8.6	103.9%
6	Гадаад албан томилолт	19	21.6	2.6	113.7%
7	Засгийн газрын дотоод шилжүүлэг	298.7	470.4	171.7	157.5%

8	Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж	4858	4865.1	7.1	100.1%
<b>Нийт</b>		<b>10286.1</b>	<b>10623</b>	<b>336.9</b>	<b>103.3%</b>

Үүнээс тээвэр шатахууны зарцуулалтыг сумдаар авч үзвэл дараах байдалтай байна.

/сая.төг/

Д/д	Сумдын нэр	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Гүйцэтгэлийн хувь	Хэтэрсэн дүнд эзлэх хувийн жин
1	Булган аймаг	69.94	73.47	-3.53	105.0%	68.0%
2	Баян-Агт	22.84	22.84	0.00	100.0%	
3	Бугат	25.34	25.34	0.00	100.0%	
4	Бүрэгхангай	21.88	22.09	-0.21	101.0%	4.1%
5	Гурванбулаг	29.78	29.78	0.00	100.0%	
6	Дашинчилэн	23.96	23.93	0.03	99.9%	
7	Могод	26.11	25.96	0.15	99.4%	
8	Орхон	16.86	16.94	-0.08	100.5%	1.5%
9	Сайхан	24.13	24.13	0.00	100.0%	
10	Сэлэнгэ	31.05	31.04	0.00	100.0%	
11	Тэшиг	37.07	37.07	0.00	100.0%	
12	Хангал	13.53	13.29	0.24	98.2%	
13	Хишиг-Өндөр	9.43	9.42	0.02	99.8%	
14	Хутаг-Өндөр	22.95	23.88	-0.92	104.0%	17.8%
15	Баяннуур	33.76	33.94	-0.19	100.5%	3.6%
16	Рашаант	33.13	33.05	0.09	99.7%	
17	Хялганат	21.13	21.06	0.07	99.7%	
18	Булган	52.39	52.66	-0.26	100.5%	5.0%
<b>Хэтэрсэн дүн</b>				<b>-5.19</b>		
<b>Хэмнэсэн дүн</b>				<b>0.61</b>		
<b>Нийт</b>		<b>515.31</b>	<b>519.89</b>	<b>-4.58</b>	<b>100.9%</b>	<b>100.0%</b>

#### Нэмэлт санхүүжилтийн зарцуулалт:

Нэмэлт санхүүжилтийн нэгтгэсэн тайлангаар тайлант онд 2362.8 сая төгрөгийн эх үүсвэр бүрдүүлж 2269.8 сая төгрөг зарцуулж 92.9 сая төгрөгийг аймаг, сумын ерөнхий орлогын дансанд төвлөрүүлсэн байна.

#### Тусгай шилжүүлэгийн зарцуулалт:

Төсвийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1-д “ Аймаг, Нийслэлийн Засаг дарга Засгийн газрын дараах чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлнэ.” гэж заасан.

Үүнд:

- Ерөнхий боловсрол
- Сургуулийн өмнөх боловсрол
- Соёлын үйлчилгээ
- Эрүүл мэнд
- Газрын харилцаа

- Хүүхэдийн хөгжил, хамгаалалын үйлчилгээ
- Нийтийн биеийн тамир

Төсөвт батлагдсан тусгай зориулалтын шилжүүлгийн 29535.7 сая төгрөгийг төсвийн хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1-д заасны дагуу санхүүжүүлсэн байна.

Гүйцэтгэлээр 29642.3 сая төгрөг буюу төлөвлөгдсөн нийт зардал 99.5 хувийн гүйцэтгэлтэй байна. БХБС 67.2 улсын төсөвт төвлөрүүлдэг орлого, 0.4 төсвөөс хэмнэгдэж төвлөрүүлсэн дүн, БСШУС 142.8 сая төгрөгөөс 139 төсвийн хэмнэлт, 3.8 нэмэлт санхүүжилт, ЭМС 32.2 сая төгрөг, ХНХ сайд 1.2 сая төгрөг төсвийн хэмнэлтээс нийт 243.4 сая төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

Тусгай шилжүүлэгтэй холбоотой хөрөнгийн задаргаа

Үзүүлэлт	Нийт дүн	ЭМС-ын сайд	ХАХНХ-ын сайд	БСШУ-ын сайд	БХБсайд
Мөнгөн хөрөнгө	42.6	42.6	-	-	-
Авлага	48.7	10.9	17.6	20.2	-
Нөөцийн бараа	3349.8	440	5.1	2867.3	37.4
Үндсэн хөрөнгө	54723.4	4268.3	589	49540	326.1
Нийт хөрөнгийн дүн	58107.1	4721.5	594,1	52428	363.5
Өр төлбөр	21.7	9.2	1.3	11.2	-

Хүснэгтээс харахад: нийт хөрөнгөд мөнгөн хөрөнгө 0.07, авлага 0.08, бараа материал 5.8, үндсэн хөрөнгөс 94.1 хувийг тус тус эзлэж байна.

Тусгай шилжүүлгийн 78 байгууллагын 13 байгууллагад дүгнэлтэнд хамруулж 2 байгууллагыг өмнөх санхүүгийн аудитын тайлангийн дүнг үндэслэн итгэл үзүүлж үлдсэн байгууллагуудыг түүвэрт хамруулсан байна. СТА-ын гүйцэтгэлтэй холбогдуулан нийтлэг илэрсэн алдаа зөрчлөөс дурьдвал. Үүнд:

- Сумдын ЭМТ-үүд 2017 онд 298 орон тоо батлагдаж гүйцэтгэлээр 290 хүн ажилласан нь Баян-Агт 2, Гурванбулаг 2, Орхон 2, Рашаант 1, Хангал 2 нийт 9 орон тоо дутуу ажиллаж, Могод сумын ЭМТ 1 орон тоо илүү ажилласан,
- Төсвийн тухай хуулийн 6.4.8 дахь Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх гэсэн заалтыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй,
- Үндсэн хөрөнгө болон бараа материалд тавих хяналт сул, санхүүгийн тайланд хандиваар ирсэн хөрөнгийг орхигдуулж, алдаатай тайлагнасан,
- Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны зааврын дагуу бүртгээгүй,
- Хүүхдийн хоолны хувьсах зардал 22 цэцэрлэгт төлөвлөгөөгөөр 2670 хүүхэд хамруулахаар тооцон 796109.6 мянган төгрөгийн хувьсах зардал авахаар төлөвлөн гүйцэтгэлээр 2556 хүүхэд хамруулан 828721.4 мянган төгрөгийн хоолны зардал гаргаж 114 хүүхдийн 32611.8 мянган төгрөгийн

хувьсах зардал илүү авч, хүүхдийн хоолны мөнгийг зориулалт бусаар зарцуулан хүүхдийн баяр, шинэ жилээр төсвөөс 14070.1 мянган төгрөгийн бэлэг олгосон. Нэг хүүхдэд ногдох хувьсах зардлыг илүү авсан нь Засгийн газрын 2012 оны 3 дугаар сарын 28-ны өдрийн 94 дүгээр тогтоол “Сургуулийн өмнөх боловсрол эзэмшүүлэхэд нэг хүүхдэд ногдох хувьсах зардлын дундаж нормативыг 1 дүгээр хавсралт ёсоор баталж 2012 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн мөрдсүгэй” гэсэн тогтоолыг зөрчсөн,

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25.1-д “Төрийн өмчийн эд хөрөнгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан журмаар үнэлж бүртгэнэ” гэсэн заасан заалтыг зөрчин Булган сумын 2-р цэцэрлэгийн шинэ барилгыг 2017 оны 03 сарын 16-ны өдөр барилга хүлээлцэх улсын комисс ажиллаж барилгыг ашиглалтанд хүлээн авсан, барилга 1400.0 сая төгрөгний төсөвт өртөгтэй, 1340.2 сая төгрөгний санхүүжилт авсан, уг комиссын хуралдаанаар дутуу, огт хийгээгүй 47 ажлын жагсаалт гаргасан одоогийн байдлаар 26 ажил огт хийгээгүй 20.0, 30.0 саяар 2 удаа санхүүжилт авсан боловч ажил дуусаагүй, гэтэл улсын комиссын шийдвэрийг үндэслэн барилгыг хүлээн авч 2017 оны 09 дүгээр сарын 01-нд нээлт хийж хүүхэд хүлээн авч үйл ажиллагаа явуулж уг барилгыг санхүүгийн тайланд дуусаагүй барилгад бүртгэсэн,
- Мөн үндсэн хөрөнгийн тодруулга тайланд барилга байгууламж 26773.1, тоног төхөөрөмж 16131.4, эд хогшил 7976.0, бусад үндсэн хөрөнгө 11.1 сая нийт 61934.4 сая төгрөгийн элэгдлийг илүү байгуулж тайлагнасан нь “Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар батлагдсан “Төсөвт байгууллагад мөрдөх НББ-ийн дансны заавар, санхүүгийн тайланг бэлтгэж гаргах аргачлал”-ыг бүрэн хэрэгжүүлээгүй,
- Засгийн газрын 2012 оны 10 дугаар сарын 27-ны өдрийн 106 дугаар “хоолны зардлын дундаж норматив батлах тухай” тогтоолыг 1 болон 3-т заасны дагуу хоолны зардлын нормоор олгоогүйгээс зарим сумдын сургууль үргүй зардал гаргасан бол зарим сургууль норматив зардлаар тооцон олгоогүйгээс бодит бус хэмнэлт үүссэн,
- НББ-ийн тухай хуулийн 12.1, 12.2.1 болон Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70.2-т заасан хугацаанд хөрөнгийн төрөл тус бүрээр зохих журмын дагуу хийж, баталгаажуулах, тооллогын үр дүнг энэ хуулийн 73.2-т заасан нөхцөл шаардлагын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусгах гэж заасныг бүрэн хэрэгжүүлэлгүй тооллогыг цаг хугацаанд нь чанартай бүрэн хийгээгүй зэрэг алдаа зөрчил илэрсэнд холбогдох албан тушаалтнуудад зохих акт, албан шаардлага, зөвлөмж, хариуцлага тооцуулах албан бичиг хүргүүлсэн болно.

### **Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт:**

Аймгийн ИТХ-ын 2017 онд орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 11 төсөл, арга хэмжээ 2286.7 сая төгрөгөөр батлагдаж гүйцэтгэлээр 9 төсөл, арга хэмжээнд 1447.4 сая төгрөгийн санхүүжилтыг олгож 57.4 сая төгрөг хэмнэгдэж, 3 төсөл арга хэмжээний 781.9 сая төгрөгийн ажлыг 2018 онд санхүүжүүлэхээр баталсан. Зарим ажлаас дурьдвал:

- Барилга байгууламжийн ТЭЗҮ, зураг төсөв боловсруулах ажилд 2017 онд 148.5 сая төгрөг батлагдаж 96.6 сая төгрөгийн гүйцэтгэл гарсан зураг төсвийн үнэ хэт өндөр Тухайлбал: Булган сумын төвийн гэрэлтүүлгийн өргөтгөл, шинэчлэлтийн зураг 20.0, Спорт ордонь их засварын зураг 26.3, Тамгын газрын “Г” блокны зураг 11.8, Дулаан станцын 2 дахь эх үүсвэрийг барих 8.0, Тэшиг сумын 120 хүүхдийн цэцэрлэгийн барилгын зураг 17.0, Хишиг-өндөр сумын сургуулийн хичээлийн байрны их засвар 10.0 сая төгрөгөөр хийсэн,
- Булган сумын төвийн хатуу хучилттай авто замын өргөтгөл, шинэчлэлийн ажилд 491.3 төгрөг батлагдаж “Сэлэнгэ есөн эрдэнэ” ХХК шалгарч 439.3 төгрөгийн ажил гүйцэтгэж, 52.0 төгрөгний ажил дутуу, улсын комисс хүлээж аваагүй хяналт сул,
- Булган сумын төвийн гэрэлтүүлгийн өргөтгөл, шинэчлэлийн ажил 477.1 төгрөг батлагдсан боловч ажил эхлээгүй,
- Аймгийн баяр наадмын талбайг шинэчлэн засварлах ажилд 252.8 төгрөг батлагдсан боловч ажил эхлээгүй учир 2018 онд санхүүжүүлэхээр шийдвэрлэсэн,

#### **Аймгийн авто замын:**

Булган аймгийн авто замын сан “Булган сумын зам засвар арчилалтын ажлыг чанартай хийж гүйцэтгэх” эрхэм зорилго, эрхлэх асуудлын хүрээнд дараах үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна.

Авто замын сан нь 2017 оны эхэнд 203.2 сая төгрөгний үлдэгдэлтэй, АТБӨЯХА татвараас 254.6, зам ашигласаны төлбөр хураамж 80.0 сая төгрөгний эх үүсвэр бүрдүүлэхээр төлөвлөж үйл ажиллагааны болон зам ашигласаны хураамжаас 62.6, АТБӨЯХА татвараас 245.9 сая төгрөг төвлөрүүлж, замын сангийн төсөл арга хэмжээнд 422.7 сая төгрөг зарцуулж 88.9 сая төгрөгний үлдэгдэлтэй байна. Авто замын сангийн хөрөнгийг аймгийн 2017 оны авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтын дагуу зарцуулсан байна. Үүнд:

Булган сумын авто зам, замын байгууламжийн шинэчлэлийн инженерийн зураг төсөв боловсруулах ажлын Зураг төсвийн үнэ 34.2 сая төгрөгийг “Тарваченбүүлэн” ХХК шилжүүлсэн бүртгэлгүй, Булган-Орхон сумын чиглэлийн хатуу хучилттай замын зураг төсвийн үнэ 10.0 сая төгрөгийг “Гео зураглал” ХХК шилжүүлж авлага үүсгээгүй, ажил эхлээгүй, Булган сумын авто зам, зам засварт 25.0 сая төгрөгийг аймгийн ЗД-ын шийдвэрээр Булган сум руу эрх шилжсэн юу хийсэн тодорхойгүй, тайлан аваагүй, зогсоолын ажилд нийт 333.7 сая төгрөг зарцуулж халуун ус, МСҮТ, ГХБХБГ, Жаран цайны газар зогсоолын ажлыг “Цонхот” ХХК 73.4, 1-р 12 жил зогсоол “Бүлээн оргил” ХХК 92.9, 4-р цэцэрлэг, 9-р байрны зогсоолыг “Булган барилга” ХХК 77.7, Монос эм сан, Од дэлгүүрийн зогсоолыг “Талст билэг” ХХК 62.8 сая төгрөгөөр хийж гүйцэтгэхээр гэрээ байгуулж ажлуудыг хийж гүйцэтгэсэн байна.

**Аймгийн ОНХС:**

Аймгийн ОНХСангийн хөрөнгөөр хийгдэх төсөл арга хэмжээний ажлуудыг аймгийн ИТХ-ын 2016 оны 3 дугаар хуралдааны 03/03 тоот тогтоолын хавсралтаар хөрөнгө оруулалтын 4 ажилд 668.0, тоног төхөөрөмжийн 2 ажилд 55.0, хөтөлбөр төсөл арга хэмжээний 4 ажилд 238.0 сая төгрөгийн нийт 961.0 сая төгрөгийг баталуулж, 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн IV/04 тоот тогтоолын хавсралтаар хөрөнгө оруулалтын 6 ажилд 788.8, тоног төхөөрөмжийн 2 ажилд 55.0, хөтөлбөр төслийн 4 ажилд 238.0 сая төгрөг буюу нийт 1081.8 сая төгрөгийн санхүүжилт олгохоор тодотгол хийгдэн баталж өмнөх тогтоолоос хөрөнгө оруулалтын 2 ажлын 120.8 сая төгрөгийн санхүүжилтийг нэмэгдүүлж нийт 12 ажил хийгдэхээр баталсан байна.

2017 онд ОНХС-гийн хөрөнгөөр хийгдэх 12 ажилд өмнөх оны үлдэгдэл 157.9 сая төгрөг дээр нийт 1029.1 сая төгрөгийн санхүүжилт авч гүйцэтгэлээр 1040.8 сая төгрөгийг зарцуулж оны эцэст 146.3 сая төгрөгийн үлдэгдэлтэй, нийт ажлын гүйцэтгэл 92.8 хувьтай гарч сумдад шилжүүлэх морин хуурын үнэ 3.2 сая төгрөгийн өглөгийн үлдэгдэлтэй тайлагнажээ.

Санхүүгийн тайлангийн горим сорилын түүвэрлэлтээр “Эрүүл мэндийн хөтөч” хөтөлбөр, “Оюунлаг Булган” хөтөлбөр, аймгийн баяр наадмын ажил гэсэн 3 дэд хөтөлбөрийн гүйцэтгэлийг сонгон авч гүйцэтгэлээ.

Үүнд: “Эрүүл мэндийн хөтөч” хөтөлбөрийн ажилд 17.5, “Оюунлаг Булган” хөтөлбөрийн хэрэгжилтэнд 34.1, аймгийн баяр наадмын ажилд 50.0 сая төгрөгийг тус тус санхүүжүүлж ажилласан боловч ОНХС-гаар хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээний ажлуудын хэрэгжилт санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт сул, бараа материал болон үндсэн хөрөнгийг тухайн байгууллага тайлан бүртгэлдээ тусгаагүй зөрчлүүд илэрч байна.

Тухайлбал: Эрүүл мэндийн газар нь аймгийн ЗД-ын 2017 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн А/136 тоот захирамжын дагуу “Эрүүл мэндийн хөтөч” хөтөлбөрийн төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх сургалт үйл ажиллагааг зохион байгуулан ажилласан боловч ОНХС-гаас санхүүжүүлсэн 17.5 сая төгрөгийн материалыг, мөн 29.9 сая төгрөгийн “В”, “С” вирусн лабораторийн хэрэгсэлийг нийт 47.5 сая төгрөгийн тоног төхөөрөмж, материалыг байгууллагын данс бүртгэл тайланд тусгаагүй, дотоод хяналт хариуцсан мэргэжилтэн хяналт тавьж ажилласан тухай ажлын тайлан байхгүй, эм болон эмийн хэрэгслэл тараасан тараалтын баримт дутуу, “Эрүүл мэндийг дэмжигч” болзол уралдааны 1.5 сая төгрөгийн ажил хийгдээгүй байхад санхүүжилтийг олгосон, БСУГ нь 5.0 сая төгрөгийн ном худалдан авч 16 сумын соёлын төвд тараасан гэх боловч Баян-Агт сумын соёлын төв 0.25, Могод сумы соёлын төв 0.25, Бүрэхангай сумын соёлын төв .0.25, нийт 3 сум 0.75 сая төгрөгийн ном орлогод аваагүй, санхүүгийн тайлан бүртгэлдээ тусгаж тайлагнаагүй, зэрэг зөрчлүүд илэрлээ.

Цаашид ОНХС-гийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээг ОНХС-гийн зарцуулах журамын 4.2, 4.5, 9.4 дэх заалтуудыг хэрэгжүүлэх, хяналт тавьж ажилласан тухай ажлын хэсгийн тайлан, ажлын хэрэгжилтийг тайлагнаж худалдан авсан бараа материал болон үндсэн хөрөнгийг холбогдох албан газруудын тайлан

балансад бүртгүүлэх төсөл арга хэмжээг хариуцан зохион байгуулж байгаа албан хаагчдын ажлыг сайжруулах, ОНХС-гийн хөрөнгийг арвилан хэмнэлттэй, үр дүнтэй зарцуулж байх шаардлагатай байна.

### **Сумдын ОНХС:**

Сумдын орон нутгийн хөгжлийн санд олгох санхүүгийн дэмжлэгийг 655.5 сая төгрөгөөр баталсныг аймгийн ИТХ-ын 04 дүгээр хуралдааны 04 тогтоолоор 88.3 сая төгрөгөөр бууруулж 553.9 сая төгрөг олгохоор тодотгожээ. Аймгийн 2017 оны төсвийн хоёр дахь тодотголыг 2017 оны 12 дугаар сарын 04-ний 06 дугаар хуралдааны 01 тоот тогтоолоор тодотгосон бөгөөд уг тодотголоор ОНХС-гийн санхүүгийн дэмжлэгт өөрчлөлт оруулаагүй байна.

ОНХС-гаас Булган аймгийн 16 суманд нийт 567.5 сая төгрөгийн санхүүжилт олгохоор баталж 15 сумын санхүүжилтийг бүрэн олгосон бол Булган сумын санхүүжилтийг 13.5 сая төгрөгөөр дутуу буюу нийт 553.9 сая төгрөг санхүүжилт олгосон байна.

Сумдын ОНХС нь 2017 оны эхний үлдэгдэл 741.6 сая төгрөг дээр ОНХС-гаас санхүүжүүлсэн 553.9 сая төгрөг нийт 1295.5 сая төгрөгийн эх үүсвэртэйгээр 175 төсөл арга хэмжээ хэрэгжүүлсэн байна.

### **Төсөл арга хэмжээ хэрэгжүүлэхтэй холбогдуулан гарсан нийтлэг алдаа:**

Тэшиг, Хангал, Булган сум орон нутгийн хөгжлийн сангаас Цагдаагийн бэлэн бус торгуулийн машин худалдан авахаар 10.3 сая төгрөг баталж 10.2 сая төгрөгийн санхүүжилт олгож худалдан авсан, мөн Хишиг-Өндөр сум 2.5 сая төгрөгөөр ахмадын кабинетад массажны тоног төхөөрөмж, Могод сум 1.4 сая төгрөгөөр олон нийтийн цагдаагийн цалин олгосон, 2.0 сая төгрөг автомашины засвар, 1.0 сая төгрөгөөр Соёлын төвийн дуу гаргалтын тоног төхөөрөмж, Сайхан сум Машины сэлбэгт 2.0 сая төгрөг, Сийлбэртэй гэр 17.5 сая төгрөг, Онцгой байдлын багаж 1.3 сая төгрөгөөр тус тус худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 60.3-д “Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно”, 60.3.1-д “Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр арга, хэмжээ” гэж заасныг зөрчсөн байна.

Булган сумын ОНХС-гаас Хот тохижилтийн ангид нийтийн эзэмшлийн зориулалттай олон үйлдэлт трактор худалдан авахаар 34.9 сая төгрөгөөр баталж худалдан авалт хийсэн ч дагалдах хэрэгсэл болох ногоон байгууламж услах тоног төхөөрөмж, давс цацах зориулалттай тоног төхөөрөмж дутуу нийлүүлсэнээс 17.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна. Үлдэгдэл санхүүжилт болох 17.5 сая төгрөгийг өглөгт тусгаагүй, хөрөнгийг орлогод аваагүй нь НББ-ийн тухай хуулийн 14.4 дэх заалтыг зөрчиж байна. Мөн тракторын тоног төхөөрөмж нь зах зээлийн үнэтэй харьцуулан үзэхэд өндөр байгаа нь тендерийн материал боловсруулахад үнийн судалгаа муу хийсэн мөн тендер шалгаруулахад үнийн дүнг төдийлөн харгалзан үзээгүйтэй холбоотой тул цаашид анхаарах шаардлагатай байна.

**Байгаль хамгаалах сан:**

Булган аймгийн Байгаль хамгаалах сан 3717.6 сая төгрөгийн санхүүжилт авахаас 521.4 сая төгрөгөөр дутуу буюу 3196.2 сая төгрөгийн санхүүжилт авч, үнэт цаасны орлого 7.1, бусад орлого 1.3 нийт 8.4 сая төгрөгөөр эх үүсвэрийг нэмэгдүүлж нийт 3204.5 сая төгрөгнөөс тухайн оны 33 төсөл хөтөлбөр арга хэмжээнд 2941.9, урьд оны 5 төсөл, хөтөлбөр арга хэмжээнд 254.3 сая төгрөгийг зарцуулж дансны үлдэгдэлгүй байна.

Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр хийгдэх төсөл, хөтөлбөр, хөрөнгө оруулалтыг төлөвлөхдөө зураг, төсөв, эдийн засгийн тооцоолол, хэрэгжүүлэх ажлын төлөвлөлт, хөтөлбөргүйгээр нийт 6 төсөл арга хэмжээнд 1638.8 сая төгрөгийг, Төсвийн тухай хуулийн 29.4 дэхь заалт, мөн Засгийн газрын 2014 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлангах журам”-ыг тус тус зөрчин 5 төсөл, хөтөлбөр арга хэмжээнд 61.5 сая төгрөгийг зарцуулахаар аймгийн ИТХ-аар батлуулж, дээрх төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэн ажилласан байна. Төсвийн тухай хуулийн 42.7-д “Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно” гэсэн заалтыг зөрчин хэзээ, хэрхэн, юунд зарцуулах нь тодорхойгүй шаардлагатай үед зарцуулах зардалд 78.2 мянган төгрөгийг баталж 12.7 сая төгрөгийг зарцуулсан байна.

“Булган жимс жимсгэнэ” хөтөлбөрийн хүрээнд 414.4 сая төгрөгийн суулгац, 213.1 сая төгрөгийн хашаа, 236.3 сая төгрөгийн худаг, 57.5 сая төгрөгийн усалгааны тоног төхөөрөмж, 35.0 сая төгрөгийн эрчим хүчний трансформатор, 29.9 сая төгрөгийн усалгааны систем, нийт 986.3 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэл тайланд тусгахаас Баян-Агт, Баяннуур, Бугат, Булган, Бүрэгхангай сумд нийт 146.3 сая төгрөгийн суулгац, Баяннуур, Бугат, Булган сум нийт 109.5 сая төгрөгийн худаг, Сэлэнгэ сум 10.0 сая төгрөгийн хашаа, Бугат, Сайхан сум 5.0 сая төгрөгийн хашааг тус тус бүртгэл тайланд тусгаагүй байна.

Байгаль хамгаалах сан оны эхэнд ойжуулалтын 70.7 сая төгрөгийн өглөг, сумдаас авах ойжуулалтын авлага 247.0 сая төгрөгийн авлагатай байснаас тайланд жилд 2016 оны ойжуулалтын өглөг 31.8 сая төгрөгийн өглөг, үнэт цаасны 7.1, бусад 1.3 нийт 8.4 сая төгрөгийн авлага тус тус барагдаж оны эцэст 38.7 сая төгрөгийн өглөг, 245.8 сая төгрөгийн авлагатай тайлагнасан байна. 2017 онд байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр гүйцэтгэсэн төсөл, хөтөлбөрүүдээс ойжуулалтын санхүүжилтын үлдэгдэл 48.7 сая төгрөгийг өглөгөөр тусгаагүй нь Төсвийн тухай хуулийн 6.2.3, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.4.3-д заасан заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй.

Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр Баян-Агт суманд хийгдсэн гүний худаг байршилыг ХХААГазар, сумдын удирдлагууд болон гүйцэтгэгч компанийн буруугаас өөр газарт гаргасан зөрчил илэрсэн. Хяналт муугаас захиалагчтай байгуулсан гэрээ, техникийн тодорхойлолтыг зөрчиж сумын төвөөс урд зүгт 5 км-ын зайтай Хагийн нуур орчимд гаргах худгийг зүүн урд зүгт 1-2 км-ыг зайтай далангийн урд гаргаж малчин иргэдэд хохирол учруулж, төсвийн хөрөнгийг үр дүнгүй зарцуулжээ



Байгаль хамгаалах сангийн хөрөнгөөр 2016 онд 173.5 сая төгрөгийн 400 ширхэг, 2017 онд 164.8 сая төгрөгийн 400 ширхэг хогын савыг Булган сумын айл өрх, албан газруудад байрлуулж хэрэгжүүлсэн боловч бодит байдал дээр айл өрхүүд хогийг 2 төрлийн хогийн саванд дахин ашиглах болон бусад хогоор ангилан хийхгүй, мөн ангилагдсан хогийг Тохижилт үйлчилгээний анги нийлүүлж ачаад хогийн төвлөрсөн цэгт хаяж байгаа нь хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр үр дүн, үр өгөөжгүй байна. Энэ нь хог хаягдлын тухай хуулийн 9.3.1, 9.3.4, 9.3.6, 9.3.9, заалтыг бүрэн хэрэгжүүлэн ажиллаагүй зөрчилд хог, хаягдлыг эх үүсвэр дээр нь ангилан ялгаж хаях ажлыг иргэдэд сурталчилан зохион байгуулах сургалт сурталчилгааны ажлыг шат дараатай хийх, мөн уг ажлыг гардан хэрэгжүүлэх тохижилт үйлчилгээний анги хог хаягдлыг төвлөрсөн хогийн цэгт ачиж тээвэрлэхдээ хогыг ангилан ялгалалт дээр хяналт, хариуцлага тооцдог байх ажлыг судлан хэрэгжүүлэх,

**Чацарганы суулгац:** “Хаан жимс эс би ти” ХХК 366187.5 мянган төгрөгийн өртөгтэй суулгацыг хавар 96875 ширхэг, намар 96875 ширхэг нийт 193750 ширхэг суулгацыг нийлүүлэхээр, “Хар хорин ” ХК 387500.0 мянган төгрөгийн өртөгтэй суулгацыг хавар 54390 ш, намар 139360 ш нийт 193750 ширхэг суулгацыг нийлүүлж 2017 онд нийт суулгацын өртөгийн 40 хувийг 2 үе шаттайгаар үлдэгдэл 60 хувийг 2018 онд санхүүжүүлэхээр тус тус гэрээ байгуулжээ.

Хөтөлбөрийн хэрэгжилтэнд орон нутгийн удирдлагуудын хяналт, шаардлага сул байна. Тухайлбал: Суулгацын захиалгыг тооцохдоо сумдуудаас ирүүлсэн хүсэлтийг харгалзан үзээгүйгээс Бүрэгхангай суманд 2000, Гурванбулаг сум 275 ш суулгацыг илүү нийлүүлсэн, Хишиг-Өндөр сум намар хүлээж авсан 20000 ш суулгацыг бүлүүд хүлээж авсан боловч одоог хүртэл тариалалтыг хийгээгүй, Чацаргана тариалах бүлүүдэд суулгацыг хүлээлгэн өгсөн боловч зарим сумдууд бүлүүдтэй гэрээ байгуулаагүй байна./Хишиг-Өндөр сум, Булган сум, Тэшиг сум гэх мэт/, Зарим сумд чацаргана тариалах талбайг газар зохион байгуулалтын төлөвлөгөөд тусгаагүй, бүлүүдэд хуваарилж өгсөн газрыг хуулийн дагуу эзэмшүүлээгүй, Сумдуудад 2018 онд хавар, намар нэмж тариалах тооцоо судалгаа одоо хүртэл байхгүй байна, Булган суманд иргэдэд хүлээлгэж өгсөн суулгацаас нийт 685 ш суулгацыг иргэн болон бүлүүдэд хүлээлгэн өгсөн нь тодорхойгүй дутагдуулсан.

### **Сум хөгжүүлэх сан:**

Төсөл сангийн авлага нь төсөл сангийн шугамаар иргэдэд олгож байгаа зээлийн эргэн төлөлт мөн эргэн төлөгдөх нөхцлөөр жижиг дунд үйлдвэрлэл дэмжих зорилгоор СХС-гаас олгосон зээлтэй холбоотой үүссэн бөгөөд авлагын эхний үлдэгдэл 4175.1 сая төгрөгөөс тайлант онд 104.6 сая төгрөг барагдсан байна. Тайлант онд зээлийн эргэн төлөлт хангалтгүйгээс Бугат, Гурванбулаг, Орхон, Тэшиг сумдууд огт зээл олгоогүй бусад сумдууд 165 иргэнд 694.3 сая төгрөгийн зээл олгож авлагын эцсийн үлдэгдэл 4070.7 сая төгрөг байна. Үүний 1766.5 сая төгрөгийн 546 иргэнтэй холбоотой сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт хугацаа хэтрэлттэй байна.

Сумдын сум хөгжүүлэх сангийн авлага

/ сая.төг/

Сум нэр	эхний үлдэгдэл	эцсийн үлдэгдэл	Хугацаа хэтэрсэн зээл		Хугацаа хэтэрсэн зээлийн нийт дүнд эзлэх хувь	
			Тоо	Мөнгөн дүн	Тоо	Мөнгөн дүн
Баян-Агт	174.7	215.4	23	41.7	4.2%	2.4%
Баяннуур	196.4	185	51	185	9.3%	10.5%
Бугат	213.6	213.6	52	82	9.5%	4.6%
Булган	925.2	972.2	63	340.6	11.5%	19.3%
Бүрэгхангай	183	137.1	21	85.3	3.8%	4.8%
Гурванбулаг	184.4	152.8	17	93.3	3.1%	5.3%
Дашинчилэн	187.4	131.6	40	37	7.3%	2.1%
Могод	185	170.6	12	60.5	2.2%	3.4%
Орхон	321.7	317.4	41	143.8	7.5%	8.1%
Рашаант	232.7	235.3	16	59.9	2.9%	3.4%
Сайхан	247.6	271.3	43	105.2	7.9%	6.0%
Сэлэнгэ	158.1	142.5	48	117.3	8.8%	6.6%
Тэшиг	248	236.5	48	160.9	8.8%	9.1%
Хангал	262.7	255	16	77.2	2.9%	4.4%
Хишиг-Өндөр	205.1	200.6	12	57	2.2%	3.2%
Хутаг-Өндөр	249.7	234	43	119.9	7.9%	6.8%
<b>Нийт</b>	<b>4175.1</b>	<b>4070.75</b>	<b>546</b>	<b>1,766.47</b>	<b>100%</b>	<b>100%</b>

ОНТЕЗ-ийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайлангийн төсөл сангийн авлагын судалгаанаас үзэхэд холбогдох албан тушаалтнууд авлагын тооцоог тухай бүр хийж барагдуулах талаар тодорхой арга хэмжээ аваагүй, санал санаачлага гаргахгүй байгаагаас авлага он дамжин хадгалагдаж, насжилт нэмэгдэн улмаар төлөгдөх найдваргүй болох нөхцөл байдал үүсч болзошгүй болсон байна. Бүх сумдад СХС-гийн зээлийн эргэн төлөлтөнд анхаарч, тодорхой арга хэмжээг цаг алдалгүй авах, МУ-ын Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолын 6.2. "... төслийн хэрэгжилтэд зохих журмын дагуу хяналт тавьж ажиллаагүй болох нь эрх бүхий этгээдийн хяналт шалгалтаар тогтоогдсон бол тухайн сумын Засаг дарга болон холбогдох бусад албан тушаалтанд хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ." гэсэн заалтын дагуу хугацаа хэтрэлттэй сумдын Засаг дарга нарт хариуцлага тооцох санал хүргүүлээд байна.

**Зардлын данстай холбоотой дараах нийтлэг зөрчлүүд илэрлээ.**

- Булган сумын 1 дүгээр сургууль: Тус сургуулийн захиралын тушаалаар хичээл үйлдвэрлэлийн зардлаас нийт 7860.8 мянган төгрөгийн буцалтгүй тусламж, шагнал, бэлэг авахад зарцуулсан.
- Булган сумын 2 дугаар сургууль: Үдийн цай хөтөлбөрийг Майдар царам ХХК-аар гүйцэтгүүлдэг бөгөөд тайланд онд 103227 хүүхэд өдөрт 61936.2 мянган төгрөг олгосон байна. Гэвч гэрээний дагуу урьдчилгаа олгохдоо бэлэн

мөнгөний хүсэлтээс бус нэхэмжлэхээр олгодог, үлдэгдлийг тухайн сарын нийт дүнгээр нэхэмжилдэг, 12 дугаар сарын шилжүүлгийг төрийн сангийн гүйлгээ хаахтай холбоотойгоор 20-ноос нийт хүүхэд хамрагдахаар гүйлгээ хийн тооцоо нийлсэн актаар үлдэгдэл зөрүүгүй гэж тайлагнасан нь 20-ноос хойшхи гүйцэтгэл эрсдэл агуулж байна.

- Орхон сумын сургууль: Нормын хувцас зөөлөн эдлэлийн зардлаас 571.8 мянган төгрөгөөр хоол хүнсний материал худалдан авч Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар батлагдсан журмын дагуу зардлыг бүлэг хооронд зохицуулалт хийлгүйгээр зарцуулсан зөрчил илэрлээ.
- Орхон сумын цэцэрлэг: Нийт зардлыг хэтрүүлээгүй ч шатахууны зардлыг 82.3, БҮТЭЗ-ыг 1388.1, урсгал засварын зардлыг 1999.5, хичээл үйлдвэрлэлийн зардлыг 449.1 мянган төгрөгөөр хэтрүүлэн түлш халаалтын зардлаас санхүүжүүлэн зүйл анги, бүлэг хооронд шилжүүлэн зарцуулсан.
- Өмнөх онд аймгийн ЗДТГ 65.0 сая төгрөгөөр орон сууц худалдан авч 28.0 сая төгрөгийн төлж жилийн эцсийн санхүүгийн тайланд 37.0 сая төгрөгийг өглөг үүсгээгүй үнэ төлбөргүй үндсэн хөрөнгө дансанд бүртгэсэн. 2017 онд үлдэгдэл 37.0 сая төгрөгийг төлж тайланд бараа үйлчилгээний бусад зардалд шууд бичиж тайлагнасан.
- Аймгийн ЗДТГ-ын албан хаагчдад орон байраар хангах, орон сууцны дэмжлэгийг 2017 оны 03 дугаар сарын 22-нд 30.0, 2017 оны 06 дугаар сарын 05-нд 10.0 сая төгрөгийг түлш халаалтын зардлын хэмнэлтээс төсвийн хуваарьт өөрчлөлт оруулан 4 албан хаагчдад 40.0 сая төгрөгийг олгосон нь зөрчил нь Төсвийн тухай хуулийн 42.7 дахь “Төсөвт зохицуулалт хийхдээ хөрөнгийн болон урсгал зардлыг хооронд нь шилжүүлэх, төсөвт тусгагдаагүй шинэ хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхийг хориглоно.” гэсэн заалтыг зөрчсөн байна.

## **ДҮГНЭЛТ:**

**Булган аймгийн 2017 оны төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:**

- УИХ-аас 2017 оны төсөвт хоёр удаа тодотгол хийсэнтэй холбогдуулан аймгийн ИТХ-аас аймгийн төсөвт мөн адил тодотгол хийжээ.
- Хууль эрх зүйн шаардлагыг бүрэн хангаагүй төсөл арга хэмжээг төлөвлөж баталсан,
- Орлогыг төлөвлөхдөө тооцоо судалгаа дутуу хийснээс 2615.0 сая төгрөгийн орлогыг дутуу төлөвлөсөн,
- Нийт орлого 2249.0 сая төгрөгөөр давж биелэсэн ч 10 нэр төрлөөрх 366.0 сая төгрөгийн орлогыг тасалсан,
- Нэгтгэсэн дүнгийн гүйцэтгэлээр зардалын 8 зүйл ангийн зардал хэтэрсэн ч бүлэг дотор шилжүүлэг хийн зарцуулсан,
- Төсөвт байгууллагууд Төсвийн тухай хуулийн 6.2.3, 6.3.4, 6.4.8, 29.4, 42.7, НББ-ийн тухай хуулийн 12.1, 12.2.1, 14.4, 14.4.3, 18.1, 18.2, Төрийн

болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25.1, 70.2, Хог хаягдлын тухай хуулийн 9.3.1, 9.3.4, 9.3.6, 9.3.9 болон Сангийн сайдын 2017 оны 216 дугаар журам, “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлангах журам”, ОНХС-ийн зарцуулах журамын 4.2, 4.5, 9.4 дэх, Сангийн сайдын 2013 оны 73 дугаар тушаалаар батлагдсан журмуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллаагүй,

- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн Булган сумын төвийн хатуу хучилттай авто замын өргөтгөл, шинэчлэлийн ажилд 491.3 төгрөг батлагдаж “Сэлэнгэ есөн эрдэнэ” ХХК шалгарч 439.3 төгрөгийн ажил гүйцэтгэж, 52.0 төгрөгний ажил дутуу, улсын комисс хүлээж аваагүй,
- Авто замын сангийн хөрөнгийг аймгийн 2017 оны авто замын сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтын дагуу зарцуулсан ч Булган сумын авто зам, зам засварт 25.0 сая төгрөгийг аймгийн ЗД-ын шийдвэрээр Булган сум руу эрх шилжсэн юу хийсэн тодорхойгүй, тайлан аваагүй, зогсоолын ажилд нийт 333.7 сая төгрөг зарцуулсан,
- Аймгийн ОНХС-гаас “Эрүүл мэндийн хөтөч” хөтөлбөрийн ажилд 17.5, “Оюунлаг Булган” хөтөлбөрийн хэрэгжилтэнд 34.1, аймгийн баяр наадмын ажилд 50.0 сая төгрөгийг тус тус санхүүжүүлж ажилласан боловч ОНХС-гаар хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээний ажлуудын хэрэгжилт санхүүгийн үйл ажиллагаанд тавих хяналт сул, бараа материал болон үндсэн хөрөнгийг тухайн байгууллага тайлан бүртгэлдээ тусгаагүй,
- Сумдын ОНХС нь 1295.5 сая төгрөгийн эх үүсвэртэйгээр 175 төсөл арга хэмжээ хэрэгжүүлснээс 37.9 сая төгрөгийг 60.3.1-д “Орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр хуулиар тогтоосон чиг үүргээс бусад хөтөлбөр арга, хэмжээ”-нд зарцуулсан,
- БХС-гаас санхүүжсэн “Булган жимс жимсгэнэ” хөтөлбөрийн хүрээнд 270.8 сая төгрөгийн хөрөнгийг бүртгэл тайланд тусгаагүй, холбогдох хууль эрх зүйн актыг бүрэн хангаагүй төсөл хөтөлбөрийг баталж хэрэгжүүлдэг, үр ашиггүй зарцуулалт хийдэг,
- СХС-гаас олгогдсон зээлийн эргэн төлөлт болон эргэц царцсан, хугацаа хэтэрсэн зээлийн хэмжээ нэмэгдэж байгаа ч холбогдох арга хэмжээг тухай бүрт нь аваагүй зэрэг алдаа зөрчил илэрсэнд цаашид анхаарч ажиллах шаардлагатай байна гэж дүгнэлээ.

### **ЗӨВЛӨМЖ:**

**Аудитын дүн, дүгнэлтэнд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурьдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:**

**Аймгийн ТЕЗ, Засаг дарга З.Батзориг, ЗДТГ-ын  
СТСХ-ийн дарга О.Наранжаргал нарт:**

- ✓ Зураг төсөвгүй, техник эдийн засгийн үндэслэл хийгдээгүй төсөл, арга хэмжээг хөрөнгө оруулалт болон ОНХС-гийн төлөвлөгөөнд тусгаж, хэрэгжүүлэхгүй байх,

- ✓ Орлогыг тооцоо судалгаатайгаар боломжит нөөц боломжоор бүрэн хамруулан төлөвлөж биелэлтийг ханган ажиллах,
- ✓ Төсвийн захирагч нарыг мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангаж, орон нутгийн болон тусгай зориулалтын шилжүүлгийн байгууллагуудын төсвийн зарцуулалтад гарч буй зөрчлийг арилгах,
- ✓ Дээр дурьдсан холбогдох хуулийн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж ажиллах,
- ✓ Батлагдсан төсвийг хэмнэлттэй, үр ашигтай, зориулалтын дагуу зарцуулж ажиллахыг холбогдох төсвийн захирагч нарт үүрэг болгож, үр нөлөө бүхий дотоод хяналтыг хэрэгжүүлэх.

## ХЯНАСАН:

БУЛГАН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Д.АНХБАЯР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Ж.ЭНХЦООДОЛ

## АУДИТЫН ТАЙЛАН БИЧСЭН:

АХЛАХ АУДИТОР

П.СОДНОМ

АУДИТОР

А.СУВДАА